



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/06

Бэрх хот

**Агаарын бохирдлын эх үүсвэрийн
нэгдсэн тоо бүртгэл зохион байгуулах ажлын
хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, "Агаарын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5, 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтууд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан "Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх журам", Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны Гуравдугаар хуралдааны "Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 04 дүгээр тогтоол, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/713 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус хотын хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн ажлыг холбогдох журамд заасан хугацаанд зохион байгуулж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Э.Мягмарсүрэн (ЗАА-ны дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Энхдөл (Байгаль хамгаалагч)

Гишүүд: Т.Очирбат (Газрын даамал)

Б.Болормаа (Бэрх хөгжил-ОНӨААТҮ газрын захирал)

Б.Уянга (Хэнтий ЦТСС-ын Бэрх хэсгийн байцаагч монтёр)

Ч.Балжинням (ГТУА 42-р ангийн аврагч гал сөнөөгч)

Э.Алтанцацрал (Дулааны станцын хими усны инженер)

2. Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 01 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл хугацаанд холбогдох журмын дагуу зохион байгуулж, дүн мэдээг хянаж, заасан хугацаанд төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Хотын захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/04 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАГЧ

Ч.ЭНХЖАВХЛАН

232601012